ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2024/277/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН БУМБАРДАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2024 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Өлзийт экаунт аудит” ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....................3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....................5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....................8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................11
2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....................14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....................14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....................14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....................15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....................15
3.5.1 Төсвийн төлөвлөлт ....................16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл....................16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ....................16
4. АУДИТЫН ТАЙЛАН ....................17
4.1 Ерөнхий зүйл ....................17
4.2 Материаллаг байдал....................17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....................17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....................17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....................19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....................21

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/116.

танай________________-ны №__________________-т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
БУМБАРДАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Н.ОТГОНЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант 13,275.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

019020185

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **91,493,701.57** | **108,071,580.20** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **52,267,297.88** | **59,140,280.21** |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **52,267,297.88** | **59,140,280.21** |
| **3121** | **Төгрөг** | **52,267,297.88** | **59,140,280.21** |
| **31** | Төрийн сангийн харилцах | 52,267,297.88 | 59,140,280.21 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **39,226,403.69** | **48,931,299.99** |
| **351** | **Түүхий эд материал** | **0.00** | **3,510.00** |
| 35130 | Эм боох материал | 0.00 | 3,510.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **39,226,403.69** | **48,927,789.99** |
| 35420 | Аж ахуйн материал | 770,250.00 | 518,850.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,635,885.00 | 4,542,240.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 36,820,268.69 | 43,866,699.99 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **899,199,710.39** | **865,662,339.88** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **899,199,710.39** | **865,662,339.88** |
| **392** | **Биет хөрөнгө** | **825,980,127.61** | **792,502,339.88** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 904,899,190.36 | 905,999,190.36 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (109,209,015.86) | (137,169,165.62) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 46,155,873.44 | 44,836,930.52 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (31,069,772.45) | (31,986,317.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 53,254,037.18 | 54,308,037.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (38,050,185.06) | (43,486,334.97) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **73,219,582.78** | **73,160,000.00** |
| 39301 | Программ хангамж | 440,000.00 | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (380,417.22) | (440,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 73,160,000.00 | 73,160,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **990,693,411.96** | **973,733,920.08** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **990,693,411.96** | **973,733,920.08** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 990,693,411.96 | 973,733,920.08 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | **1,054,952,210.78** | **1,054,952,210.78** |
| 51101 | Өмч:-төрийн | 1,054,952,210.78 | 1,054,952,210.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(307,896,289.67)** | **(324,855,781.55)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (307,896,289.67) | (307,896,289.67) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (16,959,491.88) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 243,637,490.85 | 243,637,490.85 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **990,693,411.96** | **973,733,920.08** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,423,403,534.66** | **465,700,550.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **980,770,534.66** | **13,275,250.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 980,770,534.66 | 13,275,250.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 980,770,534.66 | 13,275,250.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 980,770,534.66 | 1,102,000.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 12,173,250.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **442,633,000.00** | **452,425,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **328,715,400.00** | **377,642,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 328,715,400.00 | 377,642,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **34,082.500.00** | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | 34,082.500.00 | 0.00 |
| | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **79,835,100.00** | **74,782,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/ орон нутгийн төсөвт байгууллага/ | 79,835,100.00 | 74,782,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **432,710,722.70** | **482,660,041.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **432,710,722.70** | **482,660,041.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **390,480,814.80** | **469,408,330.79** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **224,809,219.75** | **282,009,080.63** |
| 210101 | Үндсэн цалин | 169,486,487.98 | 209,644,515.15 |
| 210102 | Нэмэгдэл | 43,860,938.27 | 63,380,074.33 |
| 210104 | Урамшуулал | 11,461,793.50 | 8,984,491.15 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **28,124,966.47** | **34,485,157.04** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,234,443.95 | 23,816,660.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,257,788.38 | 2,785,460.06 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,806,230.58 | 2,201,968.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 433,371.57 | 506,802.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,393,131.99 | 5,174,266.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,578,023.00** | **58,031,037.91** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 41,895,818.00 | 48,224,067.91 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,682,205.00 | 9,806,970.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,881,951.47** | **4,047,473.70** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,154,650.00 | 3,843,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 80,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,727,301.47 | 204,173.70 |
| **2105** | **Норматив зардал** | **33,872,025.00** | **42,997,775.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 365,000.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,187,775.00 | 38,419,425.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,319,250.00 | 4,578,350.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,417,660.00** | **1,135,996.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,417,660.00 | 1,135,996.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **814,000.00** | **756,500.00** |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс | 814,000.00 | 756,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **44,982,969.11** | **45,945,310.51** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,370,890.00 | 7,066,040.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,047,345.00 | 1,486,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,564,734.11 | 37,393,270.51 |
| **27** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **42,229,907.90** | **13,251,711.09** |
| | Бусад урсгал шилжүүлэг | 33,979,000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,348,100.00 | 0.00 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,630,900.00 | 0.00 |
| | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 8,250,907.90 | 13,251,711.09 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,250,907.90 | 13,251,711.09 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **990,692,811.96** | **(16,959,491.88)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **990,692,811.96** | **(16,959,491.88)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **444,490,578.97** | **452,425,300.00** |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | 444,490,578.97 | 452,425,300.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,857,578.97** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,857,578.97** | **0.00** |
| 140020 | Бусад орлого | 1,857,578.97 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **442,633,000.00** | **452,425,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **328,715,400.00** | **377,642,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 328,715,400.00 | 377,642,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **34,082,500.00** | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | 34,082,500.00 | 0.00 |
| 1330 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **79,835,100.00** | **74,782,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/ | 79,835,100.00 | 74,782,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **392,223,281.09** | **442,798,417.67** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **392,223,281.09** | **442,798,417.67** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **348,135,794.22** | **429,546,706.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **224,809,219.75** | **282,009,075.63** |
| 210101 | Үндсэн цалин | 169,063,167.70 | 191,720,042.02 |
| 210102 | Нэмэгдэл | 44,284,258.55 | 81,283,133.61 |
| 210104 | Урамшуулал | 11,461,793.50 | 9,005,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **28,124,966.47** | **34,485,162.04** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,234,443.95 | 23,816,660.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,257,788.38 | 2,785,460.06 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,981,278.79 | 2,201,968.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 433,371.58 | 506,807.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,218,083.77 | 5,174,266.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,578,023.00** | **58,031,037.91** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 41,895,818.00 | 48,224,067.91 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,682,205.00 | 9,806,970.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **103,500** | 0.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 103,500 | 0.00 |
| **2105** | **Норматив зардал** | **30,378,290.00** | **41,325,780.00** |
| 210502 | Хоол, хүнс | 30,378,290.00 | 41,325,780.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,700,000.00** | **2,399,951.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,700,000.00 | 2,399,951.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **814,000.00** | **839,100.00** |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс | 814,000.00 | 839,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,627,795.00** | **10,456,600.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,627,800.00 | 7,939,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,999,995.00 | 2,517,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **44,087,486.87** | **13,251,711.09** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **33,979,000.00** | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,348,100.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,630,900.00 | 0.00 |
| | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **10,108,486.87** | **13,251,711.09** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,108,486.87 | 13,251,711.09 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **52,267,297.88** | **9,626,882.33** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **2,753,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **2,753,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **2,753,900.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 2,753,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | **(2,753,900.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **52,267,297.88** | **6,872,982.33** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **52,267,297.88** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **52,267,297.88** | **59,140,280.21** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,054,952,210.78** | **245,172,638.85** | **(332,463,362.97)** | **967,661,486.66** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 1,535,148.00 | 1,535,148.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,054,952,210.78** | **245,172,638.85** | **(330,928,214.97)** | **969,196,634.66** |
| Тайлант үеийн үр дүн | | | 990,692,811.96 | 990,692,811.96 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,054,952,210.78** | **243,637,490.85** | **(307,896,289.67)** | **990,693,411.96** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн** | 1,054,952,210.78 | 243,637,490.85 | (307,896,289.67) | 990,693,411.96 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/ | | | (16,959,491.88) | (16,959,491.88) |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,054,952,210.78** | **243,637,490.85** | **(324,855,781.55)** | **973,733,920.08** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| *Үзүүлэлт* | *Төлөвлөгөө* | *Гүйцэтгэл* | *Зөрүү* | *Хувь* |
|---|---|---|---|---|
| **Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **52,267,297.88** | **(52,267,297.88)** | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **504,692,500.00** | **445,552,317.67** | **59,140,182.33** | **88.3%** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **504,692,500.00** | **445,552,317.67** | **59,140,182.33** | **86.7%** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **504,692,500.00** | **432,300,606.58** | **72,391,893.42** | **85.7%** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 322,672,300.00 | 282,009,075.63 | 40,663,224.37 | 87.4% |
| Үндсэн цалин | 207,482,900.00 | 191,720,042.02 | 15,762,857.98 | 92.4% |
| Нэмэгдэл | 104,994,300 | 81,283,133.61 | 23,711,166.39 | 77.4% |
| Урамшуулал | 10,195,100.00 | 9,005,900.00 | 1,189,200.00 | 88.3% |
| **Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл** | **40,334,600.00** | **34,485,162.04** | **5,849,437.96** | **85.5%** |
| Тэтгэврийн даатгал | 27,427,000.00 | 23,816,660.59 | 3,610,339.41 | 86.8% |
| Тэтгэмжийн даатгал | 3,226,900.00 | 2,785,460.06 | 441,439.94 | 86.3% |
| ҮОМШӨ-ний даатгал | 2,581,600.00 | 2,201,968.08 | 379,631.92 | 85.3% |
| Ажилгүйдлийн даатгал | 645,500.00 | 506,807.22 | 138,692.78 | 78.5% |
| Эрүүл мэндийн даатгал | 6,453,600.00 | 5,174,266.09 | 1,279,333.91 | 80.2% |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **71,282,700.00** | **58,031,037.91** | **13,251,662.09** | **81.4%** |
| Гэрэл, цахилгаан | 58,540,600.00 | 48,224,067.91 | 10,316,532.09 | 82.4% |
| Цэвэр, бохир ус | 12,742,100.00 | 9,806,97.00 | 2,935,130.00 | 77.0% |
| **Норматив зардал** | **53,835,300.00** | **41,325,780.00** | **12,509,520.00** | **76.8%** |
| Хоол, хүнс | 53,835,300.00 | 41,325,780.00 | 12,509,520.00 | 76.8% |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,500,000.00** | **3,499,951.00** | **49.00** | **100.0%** |
| Урсгал засвар | 3,500,000.00 | 3,499,951.00 | 49.00 | 100.0% |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **839,100.00** | **839,100.00** | **0.00** | **100.0%** |
| Мэдээлэл технологийн зардал | 839,100.00 | 839,100.00 | 0.00 | 100.0% |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **12,228,500.00** | **12,110,500.00** | **118,000.00** | **99.0%** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 9,711,100.00 | 9,593,100.00 | 118,000.00 | 98.8% |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,517,400.00 | 2,517,400.00 | | 100.0% |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **13,251,711.09** | **(13,251,711.09)** | |
| **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **13,251,711.09** | **(13,251,711.09)** | |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 13,251,711.09 | (13,251,711.09) | |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **504,692,500.00** | **452,425,300.00** | **52,267,200.00** | **89.6%** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **377,642,600.00** | **377,642,600.00** | | **100.0%** |
| Улсын төсвөөс санхүүжих | 377,642,600.00 | 377,642,600.00 | | 100.0% |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **74,782,700.00** | **74,782,700.00** | | **100.0%** |
| Орон нутгийн төсвөөс | 74,782,700.00 | 74,782,700.00 | | 100.0% |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **52,267,200.00** | | **52,267,200.00** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 52,267,200.00 | | 52,267,200.00 | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **52,267,297.88** | **(52,267,297.88)** | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **59,140,280.21** | **(59,140,280.21)** | |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **19** | **19** | | **100.0%** |
| Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0% |
| Гүйцэтгэх ажилтан | 8 | 8 | | 100.0% |
| Үйлчлэх ажилтан | 10 | 10 | | 100.0% |

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| *Үзүүлэлт* | *Төлөвлөгөө* | *Гүйцэтгэл* | *Зөрүү* | *Хувь* |
|---|---|---|---|---|
| **Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **74,782,700.00** | **74,782,700.00** | | **100.0%** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **74,782,700.00** | **74,782,700.00** | | **100.0%** |
| **Бараа, ажил үйлчилгээний зардал** | **74,782,700.00** | **61,530,988.91** | **13,251,711.09** | **82.3%** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **71,282,700.00** | **58,031,037.91** | **13,251,662.09** | **81.4%** |
| Гэрэл, цахилгаан | 58,540,600.00 | 48,224,067.91 | 10,316,532.09 | 82.4% |
| Цэвэр, бохир ус | 12,742,100.00 | 9,806,97.00 | 2,935,130.00 | 77.0% |
| **Эд хогшил худалдан авах** | **3,500,000.00** | **3,499,951.00** | **49.00** | **100.0%** |
| Урсгал засвар | 3,500,000.00 | 3,499,951.00 | 49.00 | 100.0% |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **13,251,711.09** | **(13,251,711.09)** | |
| **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **13,251,711.09** | **(13,251,711.09)** | |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 13,251,711.09 | (13,251,711.09) | |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **74,782,700.00** | **74,782,700.00** | | **100.0%** |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **74,782,700.00** | **74,782,700.00** | | **100.0%** |
| Орон нутгийн төсвөөс | 74,782,700.00 | 74,782,700.00 | | 100.0% |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | | | | |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **19** | **19** | | **100.0%** |
| Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0% |
| Гүйцэтгэх ажилтан | 8 | 8 | | 100.0% |
| Үйлчлэх ажилтан | 10 | 10 | | 100.0% |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйл ажиллагааг танхимын болон зайны сургалтын хэлбэрийг хослуулан, үе шаттайгаар чанартай зохион байгуулж, эцэг эх асран хамгаалагчийн дэмжлэг оролцоог бүхий л хэлбэрээр дэмжин, суралцахуйд тулгарч буй бэрхшээлийг арилгах замаар хүүхэд бүрийг ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН болгон төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 15 зорилт, хэрэгжүүлэх 56 арга хэмжээтэй баталснаас нийт 96,4%-тай дүгнэгдсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,959.5 мянган төгрөгөөр буюу 0,2 хувиар *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 52,267.3 | 59,140.3 | 6,873.0 |
| Бараа материал | 39,226.4 | 48,931.3 | 9,704.9 |
| Үндсэн хөрөнгө | 899,199.7 | 865,662.3 | (33,537.4) |
| **Нийт хөрөнгө** | **990,693.4** | **973,733.9** | **(16,959.5)** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 990,693.4 | 973,733.9 | (16,959.5) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **990,693.4** | **973,733.9** | **(16,959.5)** |

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,873.0 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 9,704.9 мянган төгрөгөөр өссөн нь эцэг эхчүүдээс хүлээн авсан хүүхдийн ариун цэвэр, бичиг хэргийн материалыг бүртгэж эхэлсэн, мөн 12,173.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж 1,100.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 1,701.9 мянган төгрөг, тавилга эд хогшил 1,054.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 3,020.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 1,100.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 1,054.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 600.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,102.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 973,733.9 мянган төгрөг болж 16,959.5 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 362,735.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 73,782.7 мянган төгрөг, нийт 436,517.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 68,174.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 504,692.5 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 362,735.1 мянган төгрөгөөс 4 удаа тодотгол хийж 377,642.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 432,300.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 1,038.3 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 432,300.6 мянган төгрөг буюу 88,3 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | 71801- Сургуулийн өмнөх боловсрол | | | | |
| 1.1 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 1,298.7 | 1,180.7 | 118.0 | 90,9% |
| 1.2 | 81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 53,835.3 | 41,325.7 | 12,509.5 | 76,8% |
| 1.3 | 81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 2,622.3 | 2,622.3 | 0 | 100% |
| 1.4 | 81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 1,258.7 | 1,258.7 | 0 | 100% |
| 1.5 | 81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 259,296.9 | 224,088.1 | 35,208.8 | 88,4% |
| 1.6 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 111,597.9 | 100,294.1 | 11,303.8 | 89,9% |
| 1.7 | 80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 74,782.7 | 61,530.9 | 13,251.6 | 82,3% |
| | **Дүн** | **504,692.5** | **432,300.5** | **72,392.0** | **88,3%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 130,661.85 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Хүүхдийн хоол хүнс 46,473.4 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 10,905.3 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардал, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, төлбөр хураамжийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 73,282.7 мянган төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 118,152.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн буурсан цэцэрлэгийн хүүхдийн тоо багассантай холбоотой 12,509.5 мянган төгрөгийн хоол, хүнсийг зарцуулаагүй байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар анхан шатны баримтын бүрдлийн хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор  Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус  хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23 -ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 432,710.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,490.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,868.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг зарцуулахдаа байр ашиглалтыг 13,251.7 мянган төгрөг, норматив зардлыг 12,509.5 мянган төгрөг нийт 25,761.2 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

### Судалгааны үр дүн, нөхцөл байдлын талаар бичих

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэг бүртгэлд байгаа үндсэн хөрөнгө болон цалин хөлс, урамшуулал, байр ашиглалт, эрүүл мэндийг дэмжих, хүүхдийн хоол, багшийн мэргэжил дээшлүүлэх, цахим хэрэглээ, хэрэгжиж буй төсөл арга хэмжээтэй холбоотой 8 судалгааг ирүүлсэн байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс, 2 мэдээллийн хугацаа болоогүй хүлээгдэж байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай мөн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт тус тус нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 09-ны өдрийн 16 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| **Албан шаардлага** | 1 | **5,123.0** | 1 | **5,123.0** | **100%** |
| Зөвлөмж | 1 | | 1 | | 100% |
| **Нийт дүн** | **2** | **5,123.0** | **2** | **5,123.0** | **100%** |

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Залруулсан алдаа**

Аудитаар нийт 1,832,126.3 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл 990,692.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тайлант жилийн эд хөрөнгийн тооллогын үр дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгаж нэгтгээгүй, илтгэх хуудсыг хянаж хүлээн аваагүй 841,433.5 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д “Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар 1,216.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Албан шаардлага

Цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 1,215.0 төгрөгийн и баримтын бүрдэл хангаагүй гүйлгээ хийгдсэн нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “ нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлагналтай холбоотой алдаа | 1 | 990,692.8 | | | 1 | 990,692.8 | 1 | 990,692.8 | | | | |
| Хөрөнгийн тооллогын дүн нэгтгээгүй | 1 | 841,433.5 | | | 1 | 841,433.5 | 1 | 841,433.5 | | | | |
| **Дүн** | **2** | **1,832,126.3** | | | **2** | **1,832,126.3** | **2** | **1,832,126.3** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| И баримтын бүрдэл хангаагүй | 1 | 1,216.0 | | | 1 | 1,216.0 | | | | | | |
| **Дүн** | **1** | **1,216.0** | | | **1** | **1,216.0** | | | | | | |

**ТӨВ АЙМАГ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 03 сарын 27 өдөр Дугаар 86-17225502-ТӨА-2024/277/НА-СТА-ТШ3 Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,216,000.00 төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д " нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг, Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь**

[1]Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040022

1. Худалдан авалт хийсэн цаг тухайд нь НӨАТ-ын баримтад бүртгүүлж сар бүрийн 10-ны дотор бэлтгэн нийлүүлэгчтэй НӨАТ-ын тулгалт хийх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Зуунмод сумын Бумбардай цэцэрлэгийн эрхлэгч Н.Отгончимэг, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭЖАВ